



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/72/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим
хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ГЕГ	Гаалийн ерөнхий газар



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.13 № 59

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.ОДСҮРЭН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519543

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ





2.1. Оршил

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Одсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн хандиваар ирсэн хөрөнгийг баримтжуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Гаалийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Дэвшилтэт техник, технологид суурилсан, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлж, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэгч гаалийн байгууллага болох"-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймаг дахь Гаалийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Гаалийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Гаалийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд 16 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,501,287.7 мянган төгрөгөөс тооцон 30,025.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 24,516.8 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,1301.2 мянган төгрөгөөр буюу 0.86 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан “үндсэн хөрөнгө”, “бараа материал” данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,146.4	851.5	-294.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	114,829.5	97,491.5	-17,338.0
Үндсэн хөрөнгө	9,127,521.6	9,224,455.7	96,934.1
Нийт хөрөнгө	9,243,497.5	9,322,798.7	79,301.2
Өр төлбөр	60.3	464.6	403.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,742,699.5	3,821,196.9	78,897.4
Өмнөх үеийн үр дүн	4,875,007.8	4,875,007.8	-
Тайлангийн үеийн үр дүн		78,897.4	78,897.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	625,729.4	625,729.4	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,243,497.5	9,322,789.7	79,301.2

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь ломбоны нөөц хомсдож бусад газар хооронд шилжүүлэх зорилгоор ГЕГ-т буцаан шилжүүлсэн, ашиглалтаас хасагдаж буй тооцооны хуудас болон ашиглагдахгүй маягтуудыг ГЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн мөн ГЕГ-ийн даргын тушаалаар 300 толгой хонь “Сайншанд дахь гаалийн газар”-т шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1.06 хувиар өссөн нь “Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газар”-аас 123,921.2 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжиж ирсэн, ГЕГ-ын хөрөнгө оруулалтаар 248’631.9 мянган төгрөгийн гэрэлтүүлэг болон их засвар хийгдэж, 160’668.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 28’720.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл эд хогшил тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,821,196.9 мянган төгрөг болж 78,897.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн баланс хооронд шилжүүлэн авснаас тайлант жилд санхүүгийн үр дүнгийн тайлангаар ашигтай ажилласнаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



Дорнод Гаалийн газар тайлант онд 3'000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 4'600.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 153.3 хувиар биелүүлсэн байна

Хүснэгт 2: Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Туслах үйл ажиллагаа	3,000.0	4,600.0	-1,600.0	153.3
	Нийт дүн	3,000.0	4,600.0	-1,600.0	153.3

Тайлант онд орлого 1,600.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь туслах аж ахуйгаас, салбар боомтуудын ажилтан албан хаагчдын хүнсний хэрэгцээнд зарцуулсан малын үнийг орлого болгон төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,228,837.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,221,249.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,221,249.8 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант жилд үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого, зардал гараагүй байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 16 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 100,276.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,322.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 46,250.0 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 51,898.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 805.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1. Тайлант хугацаанд хийсэн 51,898.9 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан



шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. Цалингийн зардлыг түүвэрлэн шалгах явцад ажилтанд ээлжийн амралт болон цалинг давхардуулан 1,322.3 мянган төгрөгийг олгосон нь *Хөдөлмөрийн хуулийн 79 дүгээр зүйл “79.1. Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ...”, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4 дэх заалт заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 805.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Гаалийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Гаалийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн ашиглалт

1.1. **Илрүүлэлт:** Дорнод аймаг дахь Гаалийн газрын дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй мөн тайлант онд 850.2 мянган төгрөгийн шатахууныг тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр зарцуулсан байна.

1.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

1.3. **Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах.

1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115 975 913,21	98 343 024,04
33	АВЛАГА	1 146 361,37	851 500,00
335	Бусад авлага	1 146 361,37	851 500,00
3351	Байгууллагаас авах авлага	1 146 361,37	851 500,00
35	БАРАА МАТЕРИАЛ	114 829 551,84	97 491 524,04
351	Түүхий эд материал	21 445 487,87	21 445 487,87
35110	Тусгай зориулалттай материал	21 445 487,87	21 445 487,87
35300	Бэлэн бүтээгдэхүүн	18 001 070,80	5 724 775,00
354	Хангамжийн материал	52 742 993,17	51 791 261,17
35420	Аж ахуйн материал	29 867 138,52	28 922 506,52
35440	Түлш, шатах тослох материал	7 100,00	-
35470	Бусад хангамжийн материал	22 868 754,65	22 868 754,65
35600	Мал амьтад	22 640 000,00	18 530 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9 127 521 676,52	9 224 455 724,92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9 127 521 676,52	9 224 455 724,92
392	Биет хөрөнгө	9 032 196 676,52	9 129 130 724,92
39201	Барилга, байгууламж, орон сууц	9 585 221 789,85	9 833 853 736,85
39202	Хуримтлагдсан элэгдэл	1 086 320 010,68	1 302 560 860,64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	366 404 024,00	490 325 205,73
39204	Хуримтлагдсан элэгдэл	326 161 473,48	421 202 983,31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1 841 584 527,27	2 002 252 637,27
39206	Хуримтлагдсан элэгдэл	1 358 226 413,17	1 508 167 160,58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80 528 070,05	109 248 070,05
39208	Хуримтлагдсан элэгдэл	70 833 837,32	74 617 920,45
39214	Бусад үндсэн хөрөнгө	2 221 100,00	2 221 100,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	2 221 100,00	2 221 100,00
393	Биет бус хөрөнгө	95 325 000,00	95 325 000,00
39301	Програм хангамж	950 000,00	950 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	950 000,00	950 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	95 325 000,00	95 325 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9 243 497 589,73	9 322 798 748,96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	60 826,00	464 670,69
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60 826,00	464 670,69
413	Өглөг	60 826,00	464 670,69
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	27 773,00	5 498,00
4136	Бусад өглөг	33 053,00	459 172,69
41361	Байгууллагад төлөх өглөг	14 545,00	192 545,00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	248 119,69
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	18 508,00	18 508,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9 243 436 763,73	9 322 334 078,27
51	Засгийн газрын хувь оролцоо	9 243 436 763,73	9 322 334 078,27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3 742 699 468,58	3 742 699 468,58
512	Хуримтлагдсан үр дүн	4 875 007 883,65	4 953 905 198,19
51210	Өмнөх үеийн үр дүн	5 640 919 528,66	4 875 007 883,65
51220	Тайлант үеийн үр дүн	(765 911 645,01)	78 897 314,54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	625 729 411,50	625 729 411,50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9 243 497 589,73	9 322 798 748,96



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 262 147 935,00	1 709 975 124,00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20 900 000,00	-
110	Орлогын албан татвар	20 900 000,00	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	20 900 000,00	-
110003	Хөрөнгийн орлого	20 900 000,00	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	160 399 835,00	484 138 024,00
120	Нийтлэг татварын бус орлого	160 399 835,00	484 138 024,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	160 291 835,00	476 648 524,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160 291 835,00	476 648 524,00
120009	Бусад орлого	108 000,00	7 489 500,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 080 848 100,00	1 225 837 100,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 080 848 100,00	1 225 837 100,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 080 848 100,00	1 225 837 100,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1 501 287 616,29	1 619 184 439,42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 501 287 616,29	1 619 184 439,42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 462 531 203,22	1 611 597 101,42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	749 368 850,29	879 996 206,68
210101	Үндсэн цалин	388 397 700,17	437 946 579,09
210102	Нэмэгдэл	347 055 150,12	417 784 627,59
210103	Унаа хөөдний хөнгөдөлт	13 916 000,00	24 265 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89 300 170,82	111 415 161,38
210201	Тэтгэврийн даатгал	7 638 457,86	10 752 931,38
210202	Тэтгэмжийн даатгал	13 897 578,28	28 896 593,98
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 252 668,12	20 866 019,60
210204	Ажилгүйдлийн даатгал	30 651 315,77	26 542 288,38
210205	Эрүүл мэндийн даатгал	33 860 150,79	24 357 328,04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94 999 530,00	77 381 722,00
210301	Гэрэл, цахилгаан	34 799 000,00	34 921 227,00
210302	Түлш, халаалт	58 630 800,00	39 461 900,00
210303	Цэвэр, бохир ус	1 569 730,00	2 998 595,00
2104	Хангамж, бараа материалын зардал	32 366 426,00	37 240 162,00
210401	Бичиг хэрэг	2 800 000,00	2 744 747,00
210402	Тээвэр, шатахуун	21 822 976,00	29 946 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 057 400,00	1 024 915,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	524 400,00	724 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6 161 650,00	2 800 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28 299 551,00	40 479 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1 699 991,00	1 700 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600 000,00	1 000 000,00
210604	Урсгал засвар	25 999 560,00	37 779 000,00
2107	Томилолт, зочны зардал	4 993 900,00	2 075 500,00
210702	Дотоод албан томилолт	4 993 900,00	2 075 500,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	65 080 248,20	68 820 640,76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40 129 295,00	42 561 845,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	360 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	3 209 000,00	3 209 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	685 200,00	1 011 400,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231 000,00	429 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	322 100,00	429 500,00
210807	Газрын төлбөр	382 500,00	382 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20 121 153,20	20 437 395,76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	398 122 526,91	394 188 708,60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17 390 000,00	6 550 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300 000,00	302 700,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	380 432 526,91	387 336 008,60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38 756 413,07	7 587 338,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38 756 413,07	7 587 338,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38 756 413,07	7 587 338,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(239 139 681,29)	90 790 684,58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	526 771 963,72	11 893 370,04
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	11 893 370,04
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	526 771 963,72	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(526 771 963,72)	(11 893 370,04)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(765 911 645,01)	78 897 314,54



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1 087 676 900,00	1 231 606 597,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6 828 800,00	5 769 497,00
120	Нийтлэг татварын бус орлого	6 828 800,00	5 769 497,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4 100 000,00	4 688 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	88 000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4 100 000,00	4 600 000,00
120005	Түрээсийн орлого	2 620 800,00	923 997,00
120009	Бусад орлого	108 000,00	157 500,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1 080 848 100,00	1 225 837 100,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1 080 848 100,00	1 225 837 100,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 080 848 100,00	1 225 837 100,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1 087 676 900,00	1 231 606 597,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 087 676 900,00	1 231 606 597,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 048 920 486,93	1 223 909 759,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744 726 768,93	865 162 062,00
210101	Үндсэн цалин	541 615 076,93	664 222 995,00
210102	Нэмэгдэл	65 000 000,00	85 000 000,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29 799 000,00	41 877 000,00
210104	Урамшуулал	68 242 992,00	74 062 067,00
210105	Гэрээт ажлын хөлс	40 069 700,00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92 974 500,00	125 637 100,00
210201	Тэтгэврийн даатгал	66 403 000,00	98 168 400,00
210202	Тэтгэмжийн даатгал	6 642 900,00	6 867 200,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5 314 300,00	5 493 700,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 328 600,00	1 373 400,00
210205	Эрүүл мэндийн даатгал	13 285 700,00	13 734 400,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94 999 530,00	77 381 722,00
210301	Гэрэл, цахилгаан	34 799 000,00	34 921 227,00
210302	Түлш, халаалт	58 630 800,00	39 461 900,00
210303	Цэвэр, бохир ус	1 569 730,00	2 998 595,00
2104	Хангамж, бараа материалын зардал	31 011 567,00	37 208 315,00
210401	Бичиг хэрэг	2 800 000,00	2 720 000,00
210402	Тээвэр, шатахуун	21 777 767,00	29 938 900,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 057 400,00	1 024 915,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	524 400,00	724 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 852 000,00	2 800 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30 799 551,00	59 700 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1 699 991,00	12 900 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600 000,00	1 000 000,00
210604	Урсгал засвар	28 499 560,00	45 800 000,00
2107	Томилолт, зочны зардал	4 993 900,00	2 075 500,00
210702	Дотоод албан томилолт	4 993 900,00	2 075 500,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49 114 670,00	56 442 360,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39 846 700,00	47 620 960,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	360 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	3 209 000,00	3 209 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	685 200,00	1 011 400,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231 000,00	429 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	322 100,00	429 500,00
210807	Газрын төлбөр	382 500,00	382 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4 438 170,00	3 000 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300 000,00	302 700,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300 000,00	302 700,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38 756 413,07	7 696 838,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	109 500,00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	109 500,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	38 756 413,07	7 587 338,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	38 756 413,07	7 587 338,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 647 374 468,58	37 544 879,73	5 640 919 528,66		9 325 838 876,97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	95 325 000,00	0,00	0,00		95 325 000,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3 742 699 468,58	37 544 879,73	5 640 919 528,66	0,00	9 421 163 876,97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0,00	588 184 531,77	0,00		588 184 531,77
C07	Тайлант үеийн үр дүн			-765 911 645,01		-765 911 645,01
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 742 699 468,58	625 729 411,50	4 875 007 883,65	0,00	9 243 436 763,73
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 742 699 468,58	625 729 411,50	4 875 007 883,65	0,00	9 243 436 763,73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00		0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3 742 699 468,58	625 729 411,50	4 875 007 883,65	0,00	9 243 436 763,73
D08	Тайлант үеийн үр дүн			78 897 314,54		78 897 314,54
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3 742 699 468,58	625 729 411,50	4 953 905 198,19	0,00	9 322 334 078,27



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 228 837 100,00	1 231 606 597,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 228 837 100,00	1 231 606 597,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 228 837 100,00	1 223 909 759,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869 969 600,00	865 162 062,00
210101	Үндсэн цалин	661 118 600,00	664 222 995,00
210102	Нэмэгдэл	85 000 000,00	85 000 000,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41 877 000,00	41 877 000,00
210104	Урамшуулал	81 974 000,00	74 062 067,00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125 637 100,00	125 637 100,00
210201	Тэтгэврийн даатгал	98 168 400,00	98 168 400,00
210202	Тэтгэмжийн даатгал	6 867 200,00	6 867 200,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5 493 700,00	5 493 700,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 373 400,00	1 373 400,00
210205	Эрүүл мэндийн даатгал	13 734 400,00	13 734 400,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77 468 900,00	77 381 722,00
210301	Гэрэл, цахилгаан	35 799 000,00	34 921 227,00
210302	Түлш, халаалт	38 669 900,00	39 461 900,00
210303	Цэвэр, бохир ус	3 000 000,00	2 998 595,00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	37 240 800,00	37 208 315,00
210401	Бичиг хэрэг	2 720 000,00	2 720 000,00
210402	Тээвэр, шатахуун	29 938 900,00	29 938 900,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 057 400,00	1 024 915,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	724 500,00	724 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 800 000,00	2 800 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59 700 000,00	59 700 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12 900 000,00	12 900 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1 000 000,00	1 000 000,00
210604	Урсгал засвар	45 800 000,00	45 800 000,00
2107	Томилолт, зочны зардал	2 075 500,00	2 075 500,00
210702	Дотоод албан томилолт	2 075 500,00	2 075 500,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56 442 500,00	56 442 360,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	47 621 100,00	47 620 960,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360 000,00	360 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	3 209 000,00	3 209 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1 011 400,00	1 011 400,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	429 000,00	429 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	429 500,00	429 500,00
210807	Газрын төлбөр	382 500,00	382 500,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3 000 000,00	3 000 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	302 700,00	302 700,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302 700,00	302 700,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7 696 838,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	7 696 838,00
2103403	Төвлөрүүлэх шилжүүлэг 30%		109 500,00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		7 587 338,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1 228 837 100,00	1 231 606 597,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1 225 837 100,00	1 225 837 100,00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1 225 837 100,00	1 225 837 100,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3 000 000,00	5 769 497,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	88 000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 000 000,00	4 600 000,00
120005	Түрээсийн орлого		923 997,00
120009	Бусад орлого		157 500,00

